УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуухны техникийн шийдлийг өөрчлөх талаар

УБЗАА-ны ХИБХ-ийн дарга Т.Хэрлэн

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ “ТҮҮХИЙ НҮҮРСНИЙ ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ” 62 ДУГААР ТОГТООЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар 16-100кВт/цаг, 100кВт/цаг-аас дээш хүчин чадалтай нам даралтын уурын зуухыг цахилгаан, дулаанд холбох үйл ажиллагааг бодлогын түвшинд зохион байгуулж хэрэгжүүлэхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд даалгасан.

Тус албанаас энэ ажлыг хэрхэн зохион байгуулж байгаа Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд нийт 14 удаа хэлэлцүүлэн, тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хотын Ерөнхий менежерийн 2019.05.20-ны өдрийн А/147 дугаар тушаалаар Хотын инженерийн байгууламжийн Хэлтсийн дарга Т.Хэрлэнгээр ахлуулан Дүүргийн засаг даргын орлогч нар, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Эрчим хүчний Зохицуулах хороо, Цагдаагийн Ерөнхий газрын хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Хүрээлэн буй орчны хяналтын хэлтэс, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, Хот Байгуулалт, хөгжлийн газар, ХИХУГ, УБЦТС ТӨХК, УБДС ТӨХК, Монголын дулаан үйлдвэрлэл хангамжийн үндэсний холбооноос бүрдсэн өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

1. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ СУДАЛГААГ ЭЦЭСЛЭН ГАРГАВ

2019.05.23

Ажлын хэсэгт орсон холбогдох байгууллагууд дүрмээр хүлээсэн чиг үүргийнхээ дагуу Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нам даралтын халаалтын зуухны тоо, хүчин чадал, марк, түүхий нүүрсний хэрэглээ, ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт, үлдэгдэл нүүрсний хэмжээг нарийвчлан тогтоох, цахилгаан, дулаанд холбох үйл ажиллагааны бодлогын болон техникийн шийдлийг хэрхэн тодорхойлох, хэдэн нам даралтын зууханд утаа шүүгч шүүлтүүрийг суурилуулах, шүүлтүүрийн хийц, шүүгчийн дулаан тусгаарлах болон аюулгүй ажиллагааг хэрхэн хангах, түүхий нүүрс хэрэглэн улирлын чанартай үйлдвэрлэл явуулж буй болон экпортод гаргахаар дамжин тээвэрлэлт хийж байгаа аж ахуйн нэгжийг хэрхэн шийдвэрлэх, улс нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийн, цахилгаан, дулаан хангамжид холбогдохоор хийгдэж буй барилга угсралтын ажлыг шуурхай зохион байгуулах, хяналтыг тавихад нэгдмэл нэг ойлголттой болж хамтран ажиллахаар тогтсон байна.

1. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ СУДАЛГААГ ЭЦЭСЛЭН ГАРГАВ

2019.05.29

Улаанбаатар хотын 9 дүүргийн Засаг даргын орлогч, ТНААХ-ийн дарга 152 хороодын Засаг дарга нарыг хамруулсан хурал хийж, мэдээллийн нэгдсэн сан үүсгэхээр халаалтын зуухнуудын нэгдсэн судалгааг гаргаж ирүүлэх үүрэг өгөв.

2019.05.30

Нийслэл, дүүргийн мэргэжлийн хяналтын газар, хэлтсийн дарга нартай уулзалт хийж, Засгийн газрын 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 16-100 кВт, 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуухнуудын мэдээллийн судалгааг гаргах, хяналтын чиглэлээр хамтран ажиллах үүрэг даалгавар өгөв.

2019.05.30

16-100 кВт, 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуухтай 197 аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудтай уулзаж, цахилгаан, төвлөрсөн дулаан хангамжид холбогдох, шүүлтүүр тавих, байгаль орчны үнэлгээ хийлгэх, сайжруулсан хатуу түлш хэрэглэх асуудлыг хэрхэн зохион байгуулах талаар мэдээлэл өгөв.

2019.05.30

Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар хамтран 100кВт-аас дээш тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгж байгууллагуудад түүхий нүүрсний хэрэглэгээг ямар түвшинд авч үзэх талаар байр суурьиа нэгтгэсэн.

2019.05.31

100кВт-аас дээш хүчин чадалтай тусгай зөвшөөрөлгүй 265 халаалтын зуухын удирдлагуудтай Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ уулзалт зохион байгуулж, Засгийн газрын 62 дугаар тогтоолоор түүхий нүүрс хэрэглэхийг хориглосонтой холбогдуулан цахилгаан, төвлөрсөн дулаан хангамжид холбогдох, шүүлтүүр тавих, байгаль орчны үнэлгээ хийлгэх, сайжруулсан хатуу түлш хэрэглэхэд Захирагчийн ажлын албатай хамтран ажиллах, үүрэг өгөв.

2019.05.31

Улаанбаатар хотын Ерөнхий менежерээс “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК, “Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-уудад цахилгаан, төвлөрсөн дулаан хангамжид холбохоор хүсэлтээ гаргасан аж ахуйн нэгж байгууллага, иргэний хүсэлтийг шуурхай шийдвэрлэн, тодорхой хариу өгч байх талаар үүрэг өгөв.

1. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ СУДАЛГААГ ЭЦЭСЛЭН ГАРГАВ

2019.05.29

2019.05.30

2019.05.31



1. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ СУДАЛГААГ ЭЦЭСЛЭН ГАРГАВ

2019.07.05-09

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 5 хэлтсийн даргаар удирдуулсан мэргэжлийн баг нийслэлийн төвийн 6 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа халаалтын зуухнуудад газар дээр нь ажиллаж, дүгнэлт гаргав.

СОНГИНХАЙРХАН ДҮҮРЭГ

Ажлын хэсгийг Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Г.Ууганбаяр ахалж, 1, 2, 6, 7, 8, 9, 20, 21, 22, 24, 25, 31, 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа 100 квт-аас дээш хүчин чадалтай төрийн өмчийн 9, хувийн өмчийн 56, нийт 65 халаалтын зуух хамрагдсан.

		Үүнээс:	Байршлын тоо	Халаалтын зуухны тоо
1	ААНБ-ын тоо	Төрийн	9	18
		Хувийн	56	71
Нийт			**65**	**89**
2	Дулаанд	Холбогдох боломжтой /техникийн нөхцөл хүсэгүй/	2	3
		Техникийн нөхцөл гарсан	1	1
3	Цахилгаанд	Холбогдох боломжтой	1	2
4	Утаа шүүгч суурилуулах боломжгүй	Үйл ажиллагаа зогссон	1	2
		Тоосгоны үйлдвэр	4	4
5	Чанарын бүсэд хамаарахгүй		3	6
6	Утаа шүүгч суурилуулах шаардлагатай /төвлөрсөн дулаанд огт холбогдох боломжгүй/		53	71

1. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ СУДАЛГААГ ЭЦЭСЛЭН ГАРГАВ

2019.07.05-09

ХАН-УУЛ ДҮҮРЭГ

Ажлын хэсгийг Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Э.Энхцэцэг ахалж, 3, 4, 9, 10, 11, 12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа 100 квт-аас дээш хүчин чадалтай төрийн өмчийн 10, хувийн өмчийн 15, нийт 25 халаалтын зуух хамрагдсан.

		Үүнээс:	Байршлын тоо	Халаалтын зуухны тоо
1	ААНБ-ын тоо	Төрийн	10	20
		Хувийн	15	24
	Нийт		**25**	**44**
2	Дулаанд	Холбогдох боломжтой /техникийн нөхцөл хүсээгүй/	5	10
		Техникийн нөхцөл хүссэн хариу гараагүй	1	2
		Техникийн нөхцөл гарсан	2	5
3	Цахилгаанд	Холбогдсон	0	0
		Холбогдох боломжтой: Үүнээс:	2	4
		ААНБ-ын өөрийн хөрөнгөөр,	2	4
4	Утаа шүүгч суурилуулах шаардлагатай /төвлөрсөн дулаанд огт холбогдох боломжгүй/		16	23

1. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ СУДАЛГААГ ЭЦЭСЛЭН ГАРГАВ

2019.07.05-09

СҮХБААТАР ДҮҮРЭГ

Ажлын хэсгийг Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга Т.Хэрлэн ахалж, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа 100 квт-аас дээш хүчин чадалтай төрийн өмчийн 7, хувийн өмчийн 18, нийт 25 байршилд байгаа 43 халаалтын зуух хамрагдсан.

		Үүнээс:	Байршлын тоо	Халаалтын зуухны тоо
1	ААНБ-ын тоо	Төрийн	7	13
		Хувийн	18	30
Нийт			**25**	**43**
2	Утаа шүүгч суурилуулах шаардлагатай /төвлөрсөн дулаанд огт холбогдох боломжгүй/		25	43

1. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ СУДАЛГААГ ЭЦЭСЛЭН ГАРГАВ

2019.07.05-09

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

Ажлын хэсгийг Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга Т.Хэрлэн ахалж, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 17, 19 дугаар хорооны нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа 100 квт-аас дээш хүчин чадалтай төрийн өмчийн 4, хувийн өмчийн 11, нийт 15 байршилд байгаа 21 халаалтын зуух хамрагдсан.

		Үүнээс:	Байрш-лын тоо	Халаал-тын зуухны тоо
1	ААНБ-ын тоо	Төрийн	4	8
		Хувийн	11	13
Нийт			**15**	**21**
2	Утаа шүүгч суурилуулах шаардлагатай /төвлөрсөн дулаанд огт холбогдох боломжгүй/		15	21

1. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ СУДАЛГААГ ЭЦЭСЛЭН ГАРГАВ

2019.07.05-09

БАЯНГОЛ ДҮҮРЭГ

Ажлын хэсгийг Захирагчийн ажлын албаны Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга Б.Эрдэнэчимэг ахалж, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа 100 квт-аас дээш хүчин чадалтай хувийн өмчийн 11 халаалтын зуух хамрагдсан.

			Байршлын тоо	Халаалтын зуухны тоо
1	ААНБ-ын тоо	Үүнээс:		
		Төрийн	0	0
		Хувийн	11	13
	Нийт		**11**	**13**
2	Дулаанд	Холбогдох боломжтой /техникийн нөхцөл хүсээгүй/	1	2
3	Цахилгаанд	Холбогдсон	0	0
		Холбогдох боломжтой: Үүнээс:	1	1
		ААНБ-ын өөрийн хөрөнгөөр,	1	1
4	Утаа шүүгч суурилуулах шаардлагатай /төвлөрсөн дулаанд огт холбогдох боломжгүй/		10	12

1. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ СУДАЛГААГ ЭЦЭСЛЭН ГАРГАВ

2019.07.05-09

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

Ажлын хэсгийг Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн дарга Ц. Рэгзэдмаа ахалж, 2, 8, 9, 10, 11, 12, 14, 16, 17, 19, 21, 22, 24, 28 дугаар хорооны нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа 100 квт-аас дээш хүчин чадалтай төрийн өмчийн 14, хувийн өмчийн 35, нийт 49 байршилд 107 халаалтын зуух хамрагдсан.

		Үүнээс:	Байршлын тоо	Халаалтын зуухны тоо
1	ААНБ-ын тоо	Төрийн	14	51
		Хувийн	35	56
	Нийт		49	107
2	Дулаанд	Холбогдох боломжтой /техникийн нөхцөл хүсээгүй/	7	10
		Техникийн нөхцөл хүссэн хариу гараагүй	1	1
		Техникийн нөхцөл гарсан	11	29
3	Цахилгаанд	Холбогдсон	1	1
		Холбогдох боломжтой: Үүнээс:	2	4
		ААНБ-ын өөрийн хөрөнгөөр,	1	2
4	Тусгай зөвшөөрөл авсан		1	4
5	100квт-аас бага хүчин чадалтай		1	1
6	Утаа шүүгч суурилуулах шаардлагатай /төвлөрсөн дулаанд огт холбогдох боломжгүй/		25	57

1. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ СУДАЛГААГ ЭЦЭСЛЭН ГАРГАВ

2019 онд 100 кВт цагаас дээш хүчин чадалтай								
№	ААНБ	ААН, зуухны тоо		Дулаанд	Цахилгаанд	Хийн халаалт	Сайжруулсан түлш	Баяжуулсан нүүрс
		ААН	Зуух	Шилжүүлсэн зуухны тоо				
1	Тусгай зөвшөөрөлгүй	279	404	33	2	0	0	0
2	Тусгай зөвшөөрөлтэй	23	241	5	0	8	0	0
Нийт		302	645	38	28	8	0	0

2019 онд дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй 23 ААН-ийн 241 халаалтын зуух, тусгай зөвшөөрөлгүй 279 ААН-ийн 404 халаалтын зуух буюу нийт 302 ААН-ийн 645 халаалтын зуух байснаас төвлөрсөн дулаанд 38, Цахилгаан халаалтад 28, Хийн халаалтад 8 зуухыг холбож 16889 тн түүхий нүүрсний хэрэглээг зогсоосон байна.

1. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ СУДАЛГААГ ЭЦЭСЛЭН ГАРГАВ

Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 16-100 квт/цаг-н хүчин чадалтай халаалтын зуухны судалгаа

Дүүрэг		Баянгол	Баянзүрх	Сонгинохайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй	Налайх	Багануур	Багахангай	Нийт
Зуухны тоо	ААНБ	37	190	310	73	81	104	8	2	9	814
	Айл өрх	206	299	281	207	241	281	37	4	2	1558
Дүн		243	489	591	280	322	385	45	6	11	2372
АЧСБ-д хамаарахгүй.	ААНБ		4	1		26		8	2	9	50
	Айл өрх			1		10		37	4	2	54
	Дүн	0	4	2	0	36	0	45	6	11	104
АЧСБ-д хамаарах	Дулаанд холбогдсон	1	7			1					9
	Цахилгаандхолбогдсон	6	28	6	1	6	3				50
	Дүн	7	35	6	1	7	3	0	0	0	59
	ААНБ	30	151	309	72	48	101				711
	Айл өрх	206	299	274	207	231	281				1498
	Дүн	236	450	583	279	279	382	0	0	0	2209
Түлшний хэрэглээ (тн/жил)	ААНБ	366.0	2618.5	4354.3	2184.0	592.5	2073.0				12188.3
	Айл өрх	1593.5	2436.0	2182.0	1486.4	1480.0	2666.6				11844.5
Дүн		1959.5	5054.5	6536.3	3670.4	2072.5	4739.6	0.0	0.0	0.0	24032.

2. ХАЛААЛТЫН ЗУУХЫГ ЦАХИЛГААН ХАЛААЛТАНД ШИЛЖҮҮЛЭХ

АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН НАМ ДАРАЛТЫН ЗУУХЫГ ЦАХИЛГААН БАГА ХЭРЭГЛЭДЭГ БОЙЛУУР БОЛОН БУСАД ЭХ ҮҮСВЭРЭЭР СОЛИХ ЦЭЦЭРЛЭГИЙН НЭРС

№	Цэцэрлэг дугаар	Дүүрэг, хороо	Талбайн хэмжээ /м²/	Өргөтгөл, болон заал /м²/	Бодит хэмжээ /м²/	Зардлын тооцоо /сая.төг/
1	158 -р цэцэрлэг	СХД, 24-р хороо	950		950	61,5
2	253-р цэцэрлэг	СХД, 26-р хороо	950		950	55,0
3	155-р цэцэрлэг	ЧД, 19-р хороо	280	117	550	43,0
4	126-р цэцэрлэг	ЧД, 14-р хороо	264	144	520	41,0
5	174-р цэцэрлэг	ЧД, 17-р хороо	300	170	950	31,0
6	219-р цэцэрлэг, 135-р сургууль	ХУД,10-р хороо	1785	288	2200	64,0
7	45-р цэцэрлэг	БЗД, 27-р хороо	384		480	43,7
8	3-р цэцэрлэг	БЗД, 32-р хороо	228	300	600	51,3
9	225-р цэцэрлэг	СБД, 16-р хороо	660		1600	44,0
10	167-р цэцэрлэг	БЗД, 9-р хороо	390		800	49,0
11	169-р цэцэрлэг	БЗД, 22-р хороо	300		850	54,0
12	199-р цэцэрлэг	БЗД, 21-р хороо	319		1288	50,0
13	201-р цэцэрлэг	БЗД, 4-р хороо	696		540	44,5
14	203-р цэцэрлэг	БЗД, 4-р хороо	696		820	53,0
15	212-р цэцэрлэг, 132-р сургууль	БЗД,27-р хороо	1785	288	2073	59,0
16	213-р цэцэрлэг, 137-р сургууль	БЗД,22-р хороо	1785	288	2073	56,0

Дээрх цахилгаан халаагуурт холбогдохоор тендер зарлагдсан сургууль, цэцэрлэгүүдийн жагсаалтад нэмж орсон СХД 32 дугаар хороо 195 дугаар цэцэрлэг, СХД 24 дүгээр хороо 134 дүгээр бага сургууль, 217 дугаар цэцэрлэг, СБД 13 дугаар хороо 150 дугаар цэцэрлэг, СБД 18 дугаар хороо 166 дугаар цэцэрлэг, БЗД 21 дүгээр хороо 127 дугаар цэцэрлэгийн халаалтыг цахилгаан, хийд шилжүүлэх асуудал одоо хүртэл эхлээгүй тухай Нийслэлийн Боловсролын газраас ирүүлсэн 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 03/1326 дугаар албан тоотод дурдсан байна.

2. ХАЛААЛТЫН ЗУУХЫГ ЦАХИЛГААН ХАЛААЛТАНД ШИЛЖҮҮЛСЭН ХАЛААЛТЫН ЗУУХ

№	Дүү-рэг	Зуух-ны тоо	Төрөл	Тоо	ЦЭХ-д холбогдсон	Үүнээс			380в ТН авах	Татгалз-сан
						Цахилгаан зуух хосолсон		Дан ЦЭХ-р халдаг		
						220В	380В			
1	БГД	40	Иргэн	28	6	3		3	21	4
			ААНБ	12	3			3	7	2
2	БЗД	172	Иргэн	135	14	3	4	7	105	16
			ААНБ	37	11		1	10	24	2
3	ХУД	34	Иргэн	20	13	8	4	1	2	8
			ААНБ	14	11	3	7	1		
4	ЧД	58	Иргэн	44	10			10	26	8
			ААНБ	14	3			3	9	1
5	СБД	62	Иргэн	51	10		1	9	39	2
			ААНБ	11	3			3	8	
6	СХД	103	Иргэн	42	4		3	1	33	5
			ААНБ	61	16		7	9	41	4
Нийт		469	Иргэн	320						
			ААНБ	149						
			Бүгд	469	101	17	27	57	315	50

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/1479 тоот албан бичгээр Нийслэлийн Агаарын чанарын бүсэд байгаа 16-100кВт-ын хүчин чадалтай нийт 2209 усан халаалтын нам даралтын зуухнаас хэдэн зуухыг нь цахилгаан хангамжид холбогдох боломжтой судалгааг гаргаж өгөхийг хүсэхэд “Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Техникийн бодлогын хэлтсээс 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 2/1940 тоот албан бичгээр шугам сүлжээнд өргөтгөл шинэчлэл хийхгүйгээр техникийн нөхцөл гарган шууд цахилгаан халаагуур хэрэглэх боломжтой 469 зуухны ачаалал, газарзүйн мэдээлэл, тооцооллыг тус албанд ирүүлсэн байна.

Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн Нийслэлийн агаарын чанарын бүсэд байрлаж байгаа аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг олгохдоо халаалтын зуухыг цахилгаан хангамжид холбох шаардлага тавьсны дүнд 2019 онд 544, 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 256 аж ахуйн нэгжийг нийт **956** ширхэг халаалтын зуухыг цахилгаан халаалтад шилжүүлсэн байна..

3. ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИД ХОЛБОСОН ХАЛААЛТЫН ЗУУХ

- 2019 онд 16-100 кВт хүртэл хүчин чадалтай 58 ААН-ийн 68 халаалтын зуух, 2020 онд 46 ААН-ийн 52 халаалтын зуух нийт 104 ААН-ийн 120 халаалтын зуухыг төвлөрсөн дулаан холбосон байна.
- 2019 онд: 2019-2020 оны халаалтын улиралд нийт 84 иргэн, аж ахуй нэгж байгууллагын байнгын галлагаатай ажиллаж байсан бага болон дунд чадлын нийт 101 усан халаалтын зуухыг бүрэн зогсоож 14.48 Гкал/ц-ийн дулааны хэрэглээ бүхий 138 барилга, объектыг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбож 15234 тонн түүхий нүүрсний хэрэглээг зогсоосон байна.
- 2020 онд: 2020-2021 оны халаалтын улиралд нийт 77 иргэн, аж ахуй нэгж байгууллагын бага, дунд чадлын 83ш халаалтын зуухыг зогсоож, 19.29 Гкал/ц-ийн дулааны ачаалал бүхий 161ш барилга, объектыг төвлөрсөн дулаан хангамжид шинээр холбож ажилласан байна.
- 2021 онд шинээр шугам татаж ажиллагаанд залгасан томоохон байршлуудын хувьд: СХД-ийн 9,11-р хороо, Баянхошуу орчимд дунд оврын 8-н халаалтын зуухыг зогсоож, 20 иргэн, ААНБ-ын 3.92 Гкал/ц-ийн ачаалал бүхий 27-н барилга, объектыг төвлөрсөн дулаанд холбосон. БЗД-ийн 10-р хороо, Амгалан дулааны станц, УБТЗ-ын 2-р анги орчимд дунд оврын 18-н халаалтын зуухыг зогсоож, 9 иргэн, ААНБ-ын 9.91 Гкал/ц-ийн ачаалал бүхий 65ш барилга, объектыг төвлөрсөн дулаанд тус тус холбосон байна.

3. АГААРЫН ЧАНАРЫН БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ БАТЛАГДАВ

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаас хэлэлцүүлсэн “Агаарын чанарын бүсэд мөрдөх журам”-ын төслийг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албанаас Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан тушаал, захирамжаар “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан хатуу түлшний нөөцлөлт, түгээлт, борлуулалт, түүхий нүүрсний тээвэрлэлтийг зохицуулах журам”, “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн аж ахуйн нэгж байгууллага, иргэний дагаж мөрдөх журам”, “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд хяналт тавьж ажиллах журам” гэсэн 3 журам болгон 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн төслийг Захирагчийн ажлын алба, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын алба, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын хамтарсан хурлаар хэлэлцэж Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албанд **2019 оны 07 дугаар сарын 24-ны өдөр санал хүргүүлж тусгасан.**

Энэхүү журам 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн БОАЖЯ-ны сайд болон нийслэлийн Засаг даргын А/433, А/820 хамтарсан тушаал захирамжаар батлагдаж, 2020 онд дахин шинэчлэгдсэн. Уг захирамжийн 3.1.1-д Эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд эрчим хүчний үйлдвэрийн нормативийн дагуу хэрэглээг нь тооцож түүхий нүүрс тээвэрлэх зөвшөөрөл олгох ажлыг Захирагчийн ажлын алба зохион байгуулахыг даалгасан байна. Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос Түүхий нүүрс тээвэрлэх зөвшөөрлийн маягтын загварыг баталж, үнэт цаасаар хэвлэн хүргүүлж олгох ажлыг манай албанаас зохион байгуулж байна.

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар Баянзүрх дүүргийн 20, Сонгинохайрхан дүүргийн 21, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороог агаарын чанарыг сайжруулах бүсэд хамруулах, 9695 өрх, 115 аж ахуйн нэгж байгууллагын түүхий нүүрс хэрэглэхийг хориглох асуудлыг хэлэлцүүлж, агаарын чанарыг сайжруулах бүсэд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Орчны Бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлэн, Засгийн газрын хуралдаанд танилцуулан тусгай зөвшөөрөлгүй ААНБ-ыг нүүрс хэрэглэхийг бүрэн хориглов.

4. УУРЫН ЗУУХ АШИГЛАЖ, УЛИРЛЫН ЧАНАРТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛЖ БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН НҮҮРСНИЙ ТЭЭВЭРЛЭЛТ, АШИГЛАЛТЫН ТУХАЙ:

Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” А/1377 дугаар захирамж гарсантай холбогдуулан технологийн зуухтай барилгын материал бетон эдлэл үйлдвэрлэгч, мах боловсруулах зориулалттай бөгөөд нэгэн зэрэг 200С^0 температур, 8-16 ата даралтыг гаргадаг уур үйлдвэрлэгч 66 ААН-ийн 82 зуухны хийц бүтэц, даралт, температурын горимд тохируулан сайжруулсан түлш хэрэглэх туршилт судалгаа хийж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсгийг Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эрдэмтэн багш нартай хамтран Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2020 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн А/91 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан сайжруулсан түлшний нунтаг, сайжруулсан түлш, баяжуулсан нүүрс гэсэн 3 төрлийн түлшийг 7 төрлийн 9 зууханд 2020 оны 04 дүгээр сарын 03-наас 12-ний өдөр хүртэл 10 хоногийн хугацаанд туршилт явуулж, баяжуулсан нүүрс хамгийн тохиромжтой гэсэн дүгнэлтийг ажлын хэсэг гаргаж НЗД-ын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлсэн.

Монгол улсын засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 50 дугаар хуралдаанд Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн нам даралтын халаалтын техникийн шийдэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулан хуралдааны тэмдэглэлээр Монгол улсын Шатар сайдад тус асуудлыг судалж танилцуулах үүрэг өгсний дагуу 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/99 тоот Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын тушаалаар ажлын хэсэг байгуулан тус албаны зүгээс гаргасан техникийн шийдэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг судалж үзээд технологийн уур үйлдвэрлэж зууханд хамгийн тохиромжтой түүхий эд нь баяжуулсан нүүрс / Мидлинг / гэсэн дүгнэлт гаргасан.

4. УУРЫН ЗУУХ АШИГЛАЖ, УЛИРЛЫН ЧАНАРТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛЖ БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН НҮҮРСНИЙ ТЭЭВЭРЛЭЛТ, АШИГЛАЛТЫН ТУХАЙ:

Тус албаны “Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөж ажиллах журам”-ын 3.1.1.-д зааснаар “Тусгай зөвшөөрөлтэй болон энэхүү журмын 1.2.7-д заасан баяжуулсан нүүрс хэрэглэх хуулийн этгээдэд эрчим хүчний хэрэглээг нормативын дагуу тооцож, нүүрс тээвэрлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох асуудлыг зохион байгуулах”-ыг тус албанд хариуцуулсан бөгөөд уур үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжийг нэгдсэн удирдлагаар хангах, тээвэрлэлтэд хяналт тавих, үзлэг шалгалт хийх, цахимжуулах ажлыг эрчимжүүлэхээр “Үндэсний уур үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-тай 2020.11.02-ны өдрийн 20/03-446 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулан баяжуулсан нүүрсний тээвэрлэлт, маршрут, ашиглалт, зарцуулалт, хадгалалтын байдалд хяналт тавих, зөвшөөрөлгүй тээвэрлэлтийг таслан зогсоох, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Агаарын бохирдлыг бууруулах нийгмийн оролцоог нэмэх, ажлын уялдаа хамаарлыг зохицуулах үүднээс агаарын чанарыг сайжруулах бүсэд баяжуулсан нүүрс тээвэрлэх зөвшөөрлийн бичгийг дугаар, тоо ширхгийн дагуу акт үйлдэн “Үндэсний уур үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-д хүлээлгэн өгч тус холбооноос дамжуулан олгож байгаа нүүрс тээвэрлэх зөвшөөрлийн бичигт хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын шадар сайдын 2020 оны 123 дугаар тушаалаар Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд технологийн зориулалтаар уур үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын уурын зуухыг 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс болон хагас боловсруулсан нүүрс хэрэглэхийг хориглосонтой холбогдуулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эрдэмтэн, багш нар болон уур үйлдвэрлэгч ААН, “Үндэсний технологийн уур үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-ын төлөөллүүдийг оролцуулсан ажлын хэсэг байгуулагдан технологийн уур үйлдвэрлэгч 68 ААН-ийн зуухны техникийн шийдлийг өөрчилж 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн сайжруулсан түлш хэрэглэх судалгааны ажлыг эхлүүлээд байна.

5. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ ХАМГИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Төвлөрсөн дулаан, цахилгаан хангамжид холбогдох боломжгүй улсын болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийг хийн халаалтад шилжүүлэх харилцан ойлголцлын санамж бичгийг “Газком” ХХК-тай байгуулан Азийн хөгжлийн банкны TA9308 төсөл хөтөлбөрт хамрагдах замаар ISO14001:2004; ISO9001:2000; ISO 14001:2015 стандартуудын дагуу газын бойлер суурилуулах, “Ногоон зээл” төсөл хөтөлбөрт хамруулах боломжийг бүрдүүлж өгөв.

5. ХАЛААЛТЫН ЗУУХНЫ ХАМГИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- “Газком” ХХК нь санамж бичгийн хүрээнд 2020-2021 оны хичээлийн жилд шинээр ашиглалтанд орох 12 сургууль, цэцэрлэгийн түүхий нүүрс хэрэглэхээр төлөвлөсөн халаалтын зуухны зураг төсөл техникийн шийдлийг өөрчлөн хийн халаалтад шилжүүлэх барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн юм.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зарласан 10 сургууль, цэцэрлэгийн түүхий нүүрсний халаалтын зуухыг хийн түлшид шилжүүлэх барилга угсралтын ажлыг “Юнигаз” ХХК хийж байна.
- Монгол Улсын Шадар сайдын 2020 оны **123** дугаар тушаалаар Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд дулааны 2, 3, 4, Амгалан, Сэлбэ дэд төвийн дулааны станцаас бусад түүхий нүүрс түлж дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын зуухыг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс болон хагас боловсруулсан нүүрс /мидлинг/ хэрэглэхийг хориглосон байна.

Энэ тушаалын хориглосон хэсэгт хамаарах төрийн болон орон нутгийн өмчит сургууль, цэцэрлэг, хороо, цагдаа, цэрэг, хорихын анги зэрэг байгууллагуудын нам даралтын усан халаалтын болон уурын зуухыг төвлөрсөн дулаан, цахилгаан, хийн түлшид шилжүүлэх шаардлага бий болсон тул **“Улаанбаатар хийн сүлжээ” ХХК-**тай хамтран ажиллаж хийн халаалтанд шилжүүлэх ажил зохион байгуулагдаж байна.

6. ӨНӨӨДӨР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ХАЛАЛАТЫН ЗУУХНЫ МЭДЭЭЛЭЛ

2020 онд 100 кВт цагаас дээш хүчин чадалтай								
№	ААНБ	ААН, зуухны тоо		Дулаанд	Цахилгаанд	Хийн халаалт	Сайжруулсан түлш	Баяжуулсан нүүрс
		ААН	Зуух	Шилжүүлсэн зуухны тоо				
1	Тусгай зөвшөөрөлгүй	**235**	**334**	**17**	**16**	**45**	**174**	**82**
2	Тусгай зөвшөөрөлтэй	22	228	14	0	0	0	0
Нийт		261	571	31	16	45	174	82
2019-2020 онд НИЙТ				69	44	53	174	82

2020 онд тусгай зөвшөөрөлтэй 22 ААН-ийн 228 халаалтын зуух, тусгай зөвшөөрөлгүй 239 ААН-ийн 343 халаалтын зуух буюу нийт 261 ААН-ийн 571 халаалтын зуухнаас төвлөрсөн дулаанд 31, Цахилгаан халаалтад 16, Хийн халаалтад 45, сайжруулсан түлшинд 174, Баяжуулсан нүүрс /мидлинг/ 66 халаалтын зуухыг шилжүүлж 64650 тн түүхий нүүрсний хэрэглээг зогсоосон байна.

Нийслэлийн хэмжээнд 200-2021 оны халаалтын улиралд тусгай зөвшөөрөлтэй 21 ААН-ийн 214 халаалтын зуух 58.8 мян.тн түүхий нүүрс, 66 ААН-ийн 82 халаалтын зууханд 36.6 мян.тн баяжуулсан нүүрс хэрэглэх урьдчилсан тооцоо гарсан бөгөөд өнөөдрийн байдлаар 24736 тн түүхий нүүрс, 2000 тн баяжуулсан нүүрсний ний татан авалтыг хийсэн байна.

7. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын шадар сайдын 2020 оны 123 дугаар тушаалаар Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд технологийн зориулалтаар уур үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын уурын зуухыг 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн халаалтын зуухыг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрсний хэрэглээг тус тус хэрэглэхийг хориглосон.

Дээрх шийдвэртэй холбогдуулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эрдэмтэн, багш нар болон уур үйлдвэрлэгч ААН, “Үндэсний технологийн уур үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-ын төлөөллүүдийг оролцуулсан ажлын хэсэг байгуулагдан технологийн уур үйлдвэрлэгч 68 ААН-ийн зуухны техникийн шийдлийг өөрчилж 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн сайжруулсан түлш хэрэглэх судалгааны ажлыг эхлүүлэх,

.....

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА